

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК**

Огноо: 2020-04-02



**“ПРИНТЕР, ХЭВЛЭХ, ХУВИЛАХ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОР  
ХУДАЛДАН АВАХ” ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**ДҮТ-2020-04-26**

**Төслийн дугаар:** .....

**Тендер  
шалгаруулалт  
дугаар:**

**Бүртгэлийн дугаар ДҮТ/202001026**

.....

**Улаанбаатар хот**

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

Диспетчерийн Үндэсний Төв ХХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **Принтер, хэвлэх, хувилах төхөөрөмжийн хор** нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020** оны **04** сарын **13**-ны өдрийн **10** цаг **00**минутаас өмнө **Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд** ирүүлнэ.

Үнийн саналыг **2020** оны **04** сарын **13**-ны өдөр **10** цаг **30** минутад нээнэ.

Тендерийн нээлтэд сонирхсон этгээд оролцох эрхтэй бөгөөд тендерт оролцогч системд нэвтрэн орж тендерийн нээлттэй танилцах эрхтэй.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

<https://tender.gov.mn> цахим хаяг болон

**Монгол улс, Улаанбаатар хот ,  
Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг,  
3-р хороо, Засгийн газрын 14-р байр  
“Диспетчерийн үндэсний төв ХХК”-ийн  
415 тоот өрөө. Утас:70042514-333**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах мэдээллийг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улсын гэрчилгээний хуулбар/нотариатаар баталгаажуулсан/</li> <li>2. Татварын ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>4. Бараа нийлүүлэлтийн хуваарь</li> <li>5. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан /2018,2019 он аудитаар баталгаажуулсан/;</li> <li>6. Сүүлийн хоёр жилийн /2018, 2019/ тус бүрд борлуулалтын орлого нь төсөвт өртгөөс багагүй байх</li> <li>7. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /2018, 2019 он гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/</li> <li>8. Ижил төстэй гүйцэтгэсэн ажлын өртөг нь 2018, 2019 оны аль нэг жилд төсөвт өртгөөс багагүй байх</li> <li>• Бусад нэмэлт шаардлага; <ul style="list-style-type: none"> <li>✓ Компанийн танилцуулга</li> <li>✓ Улаанбаатар хотод дэлгүүр, худалдааны үйл ажиллагаа явуулдаг болохыг нотлох баримт /түрээсийн гэрээ, ... гэх мэт/</li> </ul> </li> </ol> <p>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендер нь цахим тендер шалгаруулалт журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем / <a href="https://tender.gov.mn/">https://tender.gov.mn/</a>-д өөрийн аж ахуйн нэгжийн нууцлалын кодоор нэвтрэн орж цахим хэлбэрээр ирүүлнэ. Холбоо барих утас: 70042514-333</p> <p>Огноо: <b>2020 оны 04 сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p> <p><b>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><b>Монгол улс, Улаанбаатар хот , Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр “Диспетчерийн үндэсний төв ХХК” 415 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 04 сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТОӨЗ 2.3	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч

	<p>боловыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан</li> <li>- Улсын гэрчилгээний хуулбар/нотариатаар баталгаажуулсан/</li> <li>- Татварын ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт</li> </ul>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>“Багцгүй”</b>

**Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК  
2020 ОНД ХУДАЛДАН АВАХ ХЭВЛЭХ ХУВИЛАХ  
ТӨХӨӨРӨМЖИЙН ХОР**

№	Материалын нэр	X/нэгж	Тоо	Дүйцэх марк	Шаардага
1	HP 85A	ш	15		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
2	HP12A	ш	18		
3	HP 78A	ш	40		
4	HP 88A	ш	3		
5	HP 83 A	ш	6		
6	HP 230/177/	ш	20		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
7	HP 42 A	ш	6		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
8	SHARP 2610 Black	ш	4		
9	SHARP 2610 CA	ш	4		Үйлдвэрийн лацтай байх, чип нь таараах
10	SHARP 2610 өнгөт хүнд хор	ш	1		Үйлдвэрийн лацтай байх
11	SHARP 2610 хар хүнд хор	ш	1		Үйлдвэрийн лацтай байх
12	Samsung ML10011	ш	3		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх

13	NPG 51	ш	7		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
14	NPG 67	ш	10		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
15	311A/351A	ш	7		Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх
16	Факсын хор	ш	6		Хэмжээ 70м, Panasonic брэндтэй дүйцэхүйц
<b>Нийт дун</b>				<b>151</b>	

Худалдан авалтын нөхцөл:

- Худалдан авалтын тоо хэмжээнд хатуу нөхцөл тавихгүйгээр сар, улирлаар тухай бүрд хэрэгцээгээрээ захиалах боломжтой байх
- Улаанбаатар хотод дэлгүүртэй, хүргэлттэй байх
- Төсөвт өртөгтөө багтаан нэр төрлийн хувьд сонголт хийх боломжтой байх

### **БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д зассан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермиин нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа			
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа /гэрээний хугацаа/	Нийлүүлэх эцсийн хугацаа/	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9
Хэвлэх, хувилах төхөөрөмж ийн хор	Хайрцаг сав баглаа боодол үйлдвэрийн лацтай байх, хэвлэх тоо стандартад нийцсэн байх	151	ширхэг	УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14-р байр “Диспетчерийн үндэсний төв ХХК” 415 тоот өрөө	Гэрээ байгуулс ан өдрөөс сар, улирал бүр	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд	Захиалга өгснөөс хойш 3 хоногийн дотор	

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЛЖИННЯМ \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [too] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал Үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. <b>Хүлээн авсан бараа нь чанарын шаардлага хангахгүй тохиолдолд барааг солих , шаардлагад нийцүүлэх.</b><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br><b>Тухай бүр захиалсан барааг бүрэн хүлээн авснаар хүлээн авсан баримт болон нэхэмжлэлийн дагуу 14 хоногт багтаан төлбөрийг төлнө.</b>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[0.1]</b><br>Алдангийн нийт дүн: <b>[10]</b>  |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тооогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]